Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах нь

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

MERIT төслийн зөвлөх, Мишэл Филион

2021 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Агуулга

Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах нь яагаад чухал бэ?

Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг хэрхэн тусгах бэ?

Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах таван алхам

Макро түвшний зөрүү ба төсвийн зарлагын сонголт

Татвар, төсвийн орлого

Соёл
ба нийгэмшил

Үндэслэл

Бодлого төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах нь чухал юм. Учир нь:

- Дэлхий дахинд охид, эмэгтэйчүүд тэгш эрхийн боломжоо эдэлж чадахгүй байсаар байна.
- Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу холбогдох зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Жендэрийн тэгш байдал нь хөгжил дэвшилд хөтлөх хүчин зүйлс мөн гэдгийг эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд илтгэдэг.
- Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын хөтөлбөр (PEFA)-т бодлогод жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах нь төсвийн санхүүгийн удирдлагын үндсэн мөн чанар гэж үзэж эхэлсэн.

Олон улсын холбогдох гэрээ, конвенц

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах олон улсын конвенц;
- Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол;
- Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц.

Үндэсний хэмжээний хууль тогтоомж, бодлого, стратеги

- Монгол улсын үндсэн хууль (1992);
- Иргэний хууль (2002);
- Хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль (1999);
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2005);
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011);
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга (2019);
- Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг;
- Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл (2021-2025 он);
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр);
- Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоол;

Жендэрийн тэгш байдлын эдийн засагт үзүүлж буй нөлөө

Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгаснаар хөгжил дэвшилд ямар нөлөө үзүүлж байгааг Дэлхийн Банк 2012 онд тайлагнасан. Тухайлбал:

- Бүтээмж нэмэгдсэн;
- Хойч үедээ үлдээх үр өгөөж нэмэгдсэн;
- Шийдвэр гаргалтад бүх талын оролцоо нэмэгдсэн.

Дасгал 1

Бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах үндэслэлийг товч тайлбарлан бичнэ үү.

- Өмнөх хэсгүүдэд яригдсан зүйлсээ ашиглах.
- Өөрийн тайлбарыг нийтэд танилцуулах.

Бодлого төлөвлөлтөд жендэрийг тусгах боломжит арга зам

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тухай хууль, ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль, тэгш цалин хөлс олгох тухай хууль зэрэг ач холбогдол бүхий хууль тогтоомжийн зохицуулалтад анхаарч ажиллах;
- Ялгаварлан гадуурхах явдлыг зогсоох зорилгоор хяналтын хороо, ажиглалтын механизмыг бий болгох;
- Макро түвшний, салбарын бодлогод дүн шинжилгээ хийх;
- Хөтөлбөрийн үр дүн эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлж буйг ашиг шим хүртэгчид, албан хаагчийн хүйсээр ангилан дүн шинжилгээ хийх.

Макро түвшний зөрүү

Дэлхий дахинд эмэгтэйчүүдэд дараах нөхцөл байдал түгээмэл байна. Үүнд:

- Жендэрээс хамаарсан цалингийн зөрүү
- Боловсролын түвшний зөрүү (Монгол Улсын хувьд асуудал биш)
- Тэтгэврийн зөрүү;
- Улс төр дэх төлөөлөл, оролцооны зөрүү;
- Шийдвэр гаргах түвшний албан тушаалын зөрүү;
- Өмч, хөрөнгө эзэмших байдлын зөрүү.

Төсвийн зарлагын сонголт

Дэлхий дахинд дараах хүчин зүйлс эерэг нөлөө үзүүлж байна:

- Хүүхэд асрах тогтолцоо;
- Асран халамжлагчдад үзүүлэх дэмжлэг туслалцаа;
- Шимтгэл төлөөгүй ч хувь тэнцүүлэн тэтгэвэр олгох тогтолцоо;
- Амьдралын чанарт нийтийн тээврийн үзүүлэх нөлөө;
- Нийтийн номын сан, олон нийтэд мэдлэгийг тэгш хүртээмжтэй түгээх тогтолцоо.

Пакистан улсын жишээ

- Шинэ зүйл биш
- Пакистан улсын 2005 оны туршлага



Төрийн бодлогын үнэлгээ, Пакистан улс

- Тус улсын эрдэмтэн судлаачид боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн бодлогын жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээг хийсэн;

- Хэрэгцээ шаардлагыг ойлгох, жендэрийн тэгш бус байдлын зөрүүг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын шинжилгээ, салбарын төсөв, бодлогын үр дүн, нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн;

- Судалгааны үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулж, төсвийн үйл явцын хүрээнд салбар бүрийн тайланд заавал тусгах суурь мэдээллийг бий болгосон.

Үр шим хүртэгчдийн судалгаа, Пакистан улс

- Төсвийн хөрөнгө оруулалт, төрийн үйлчилгээний иргэдэд үзүүлэх нөлөөллийн талаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн санаа бодлыг сонсох зорилгоор үр шим хүртэгчдийн судалгааг цөөн тооны мужид хийсэн;

- Судалгаа нь үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг хүйсээр тодорхойлох зорилготой байсан;

- Судалгааны үр дүнг холбогдох албан хаагчдад танилцуулж, дараа жилийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтөд ашиглахыг чиглэл болгожээ.

Цаг ашиглалтын судалгаа, Пакистан улс

- Пакистан улсын Статистикийн албанаас нийт 20,000 өрхийг хамруулсан цаг ашиглалтын судалгааг хийжээ;
- Цалин, хөлсгүй хөдөлмөр, асрах ажил хөдөлмөр эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилан шинжилсэн;
- Судалгааны тоо мэдээллийг төрийн бодлого, хөтөлбөр, төсөв боловсруулахад ашиглаж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн мэдэгдэл, Пакистан улс

Төрийн байгууллагын зүгээс УИХ-ын гишүүд, иргэний нийгмийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн санал санаачилгыг хэрэгжүүлэх төсвийн хуваарилалтын талаар мэдээлэл хүргэх хариуцлагын арга хэрэгсэл юм.

Жендэрийн дүн шинжилгээ хийх таван алхам

- Тухайн салбар дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
- Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн нөхцөл байдалд бодлогын шинжилгээ хийх;
- Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэхэд төсвийн хуваарилалт хангалттай эсэхэд үнэлгээ хийх;
- Төсвийн бодит зарлагад үнэлгээ хийх зорилгоор төсвийн зарлагын богино хугацааны үр дүнг үнэлэх;
- Зарлагын урт хугацааны үр дүн буюу нөлөөг үнэлэх;

Ахисан түвшинд судлах: дүн шинжилгээний хүрээ

- Харвардын дүн шинжилгээний хүрээ, үүнийг жендэрийн үүргийн хүрээ гэдэг Harvard Analytical Framework, also called the Gender Roles Framework;
- Мозерын жендэрийн төлөвлөлтийн хүрээ

  Moser conceptual framework;
- Леэвийн ойлголтын тогтолцоо, институтчлалын тор гэж нэрлэдэг

  Levy conceptual framework, known as the web of institutionalisation;
- Чадавх болон эмзэг байдлын үнэлгээний хүрээ

  Capacities and vulnerabilities approach (CVA);
- Ниала Кабирын нийгмийн харилцааны арга

  Naila Kabeer’s social relations approach;
- Жендэрийн дүн шинжилгээний матриц

  Gender analysis matrix framework;
- 4R аргачлал / *4R method.*

Шалгах хуудас

Шинээр бодлогын төсөл боловсруулан өргөн барьж буй байгууллага дараах зүйлийг тусгасан байх:

- Салбарын хүйсээр ангилсан дүн шинжилгээ;
- Тухайн бодлого жендэрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай тайлбар;
- Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн нөөц боломж хангалттай эсэх;
- Жендэрийн асуудлыг шийдэхэд чиглэсэн өмнөх оны төсвийг зарцуулалтын тоо мэдээлэл байгаа тохиолдолд тусгах, мөн зарцуулалтыг хэрхэн сайжруулж болох тухай саналыг;
- Тухайн бодлогын жендэрийн урт хугацааны нөлөөллийг тусгах.

Дасгал 2

Бодлогын төсөл боловсруулахад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгасан эсэхийг хэрхэн шалгах вэ? 5 хүртэлх түлхүүр үгэнд багтаан бичих.

- Өмнөх хэсгүүдэд яригдсан зүйлсээ ашиглах.
- Бичсэн мэдээллээ кейс ажилбарт ашиглах.

PEFA шалгуур үзүүлэлтүүд (1)

- Төсвийн бодлогын төсөлд хийх жендэрийн нөлөөллийн дүн шинжилгээ;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжтэй менежмент;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн удирдамж;
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн санал, баримт бичиг боловсруулалт;
- Төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хүйсээр ангилсан тоо мэдээлэл;

PEFA
Public Expenditure and Financial Accountability

PEFA шалгуур үзүүлэлтүүд (2)

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн төсвийн зарцуулалтыг тусгайлан бүртгэж, тайлагнах;
- Жендэрийн мэдрэмжтэй тайлагналт;
- Төрийн үйлчилгээний жендэрийн нөлөөллийн үнэлгээ;
- Төсвийн жендэрийн нөлөөллийн эрхзүйн (нийцлийн) хяналт шалгалт.

PEFA
Public Expenditure and Financial Accountability

Татвар, төсвийн орлого

Засгийн газрын орлого бүрдүүлэх арга зам нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлдөг.

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг татварын бодлогын шинжилгээнд тусгах нь төрийн бодлогын үр дүн, чанарыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг.

Макро түвшний бодлого: нийгэмшил

- Төр олон нийтэд боловсрол олгох, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхдийн нийгэмшлийн талаар ямар мэдээллийг хүн ам, айл өрх, эцэг эхчүүдэд өгч байна вэ?
- Уг мэдээлэл нь тэгш бус байдлыг бататгаж, нэмэгдүүлж байгаа эсэх?

Макро түвшний бодлого: соёл

- Түүх, соёл, үлгэр домогт эмэгтэйчүүдийг хэрхэн дүрсэлдэг вэ?
- Бид тэдний хувь нэмрийг эн тэнцүү авч үздэг үү? Тэдний оруулж буй хувь нэмрийг зөвөөр үнэлж хүлээн авдаг уу?

- Бид ямар төрлийн соёлыг бий болгож байна вэ?

Дүгнэлт: Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төсөв боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх аль ч шатанд хийж болно;

- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь төсвийн зарцуулалт, татварын хяналт шалгалттай л адил ойлголт бөгөөд төрийн бодлого, төлөвлөлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлж буйг үнэлэх арга юм;

- Уг арга нь аливаа бодлого, төлөвлөлт үр шим хүртэгчид болон цалин хөлсөнд хэрхэн нөлөөлөхийг хүйсээр ангилан үнэлэх арга юм.

Дэлгэрэнгүйгээр, төрийн бодлого, төлөвлөлт нь нийгэмшил, соёл, төрийн үйлчилгээнд хэрхэн нөлөөлж, эс нөлөөлж буйг цогцоор үнэлэх үйл явц юм.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Canada

Mongolia:
Enhancing Resource Management through Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000